



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 56

Мандалговь

Үндсэн хөрөнгөд үнэлгээ тогтоож,
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 78,500,000 /далан найман сая таван зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 55,526,041.77 /тавин таван сая таван зуун хорин зургаан мянга дөчин нэгэн төгрөг далан долоон мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 63-01 ДУЭ улсын дугаартай TOYOTA LAND CRUISER 200 маркийн автомашины худалдах доод үнийг 25,000,000 /хорин таван сая/ төгрөгөөр тогтоон, нээлттэй дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адьяасүрэн), Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
56 дугаар тогтоолын хавсралт

Сайнцаган сумын Засаг даргын тамгын газрын дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглагдсан огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өрөг
			Серийн дугаар	Дугаар			Арлын дугаар	Моторын эзлэхүүн /см3/	Моторын дугаар				
1	Суудал	TOYO TA LAND CRUIS ER	ДүЭ	63-01	2010	2010-12-02	JTMHU09 J6A50369 31	3956.B		294692	78,500,000	22,973,958.23	55,526,041.77
Хөрөнгийн дүн													
											78,500,000	22,973,958.23	55,526,041.77
											/далан найман сая таван зуун мянга/ төгрөг	/хорин хоёр сая есөн зуун далан гурван мянга есөн зуун тавин найман төгрөг хорин гурван мөнгө/ төгрөг	/тавин таван сая таван зуун хорин зургаан мянга дөчин нэгэн төгрөг далан долоон мөнгө/ төгрөг